



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/153/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОБЕГ	Онцгой байдлын Ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА
А.АЛТАНБАГАНА ТАНАА

2020.02.04 № 1/40

танай _____ -ны № _____ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн

Тоот-А4

005020002



хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Тоот-А4

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч А.Алтанбагана танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 02 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 18.01/15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, тохилдсон аюулт үзэгдлээс эрдэнэт хүний ам нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчноо авран хамгаалах, гамшгийн хор уршгийг арилгах, эрсдэл эмзэг байдлыг бууруулах”-д оршино.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Офицер бүрэлдэхүүний манлайлал, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдлыг сайжруулах”

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 44 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 4.01, цалингийн Payroll" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их гэж үнэлэн,

зардлын дүн 1.0 тэрбум төгрөгөөс их тул материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1211038.8 мянган төгрөгөөс тооцон 12110.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 19680.2 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 7569.8 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 он 03 дугаар улирлын санхүүгийн тайланг татсантай холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2930174.7 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	30,000.00	30,000.00	-
Бараа материал	436,982.66	541,207.63	104,224.97
Үндсэн хөрөнгө	1,977,343.77	2,358,967.15	381,623.38
Нийт хөрөнгө	2,444,326.43	2,930,174.78	485,848.35
Өр төлбөр	176.66	-	(176.66)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,444,149.77	2,930,174.78	486,025.02
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,444,326.43	2,930,174.78	485,848.35

Авлага дансны үлдэгдэлд 2016 онд үүссэн, он удаан жил болсон 30000.0 мянган төгрөгийн “Сод ноёд” ХХК-аас авах авлага байна. Уг авлагыг аудитын үед тодруулан шалгаж, барагдуулж ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 104224.9 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд Бууцагаан, Баянговь сумдад шинээр аврах анги, бүлэг нээгдсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад авч ашиглаагүй байгаа бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3560366.4 мянган төгрөг байгаа ба өмнөх оноос 699274.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ОБЕГ-аас 684274.5 мянган төгрөгийн галын автомашин, фургон машин, Өмнөговь аймгийн ОБГ-аас 17272.7 мянган төгрөгийн өртөгтэй 12090.9 мянган төгрөгийн элэгдэлтэй УАЗ-469 автомашин шилжиж ирснээс шалтгаалжээ. ОБЕГ-аас 9829.5 мянга, “Дэлхийн зөн” ОУБ-аас 6338.4 мянган төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмж, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2019.10.25-ний өдрийн А-1/3687, 2019.10.29-ний өдрийн 443 дугаар тогтоолуудаар 40742.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Биет бус хөрөнгөд санхүүгийн 2, архивын 1 программ, байгууллагын цахим хуудас зэрэг хөрөнгө бүртгэлтэй ба тайлант онд нэмж биет бус хөрөнгө нэмэгдээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны хувь хүний орлогын албан татварын өглөг 176.6 мянган төгрөгийг тайлант онд төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2930174.7 мянган төгрөг болж 486025.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газарт өөрийн орлогын төлөвлөгөө байхгүй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх нэг /70708/ хөтөлбөрт зориулан 1563686.7 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1563686.7 мянган төгрөгийг улсын төсвөөс төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Батлагдсан зардлыг 157084.6 мянган төгрөгөөр хэмнэж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1406602.1 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь дараах шалтгаантай байна.

Тайлант онд Бууцагаан сумд 32 хүний бүрэлдэхүүнтэй Гал түймэр унтраах аврах 72-р анги, Баянговь сумд 5 хүний бүрэлдэхүүнтэй Эрэн хайх, аврах бүлэг байгуулагдсан бөгөөд Бууцагаан сумын Гал унтраах ангийн үйл ажиллагаа 1 сараас эхлээд явагдах байсан хэдий ч 7 сараас эхэлж үйл ажиллагаа явуулсан. Баянговь сумын эрэн хайх аврах бүлэг 1 сараас үйл ажиллагаа явуулах байсан ч байрны асуудлаас шалтгаалж үйл ажиллагаа явуулаагүй, тухайн бүлэгт томилогдсон албан хаагчид аймгийн ОБГ-ын эрэн хайх аврах бүлэгт ажилласантай холбоотой цалингийн зардал 139002.3 мянга, тогтмол зардал 14242.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Тээврийн хэрэгслийн татварыг илүү төлөвлөснөөс шалтгаалж зардал 3556.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Нэмэлт төсөв: "Internatoinal organization for migr" ТББ-аас сургалтын зардалд 2328.8 мянга, ОБЕГ-аас гамшгийн голомтод ажилласан томилолтын зардал, байгууллагын сантехникийн засварын зардалд 34899.6 мянган төгрөг олгож, аймгийн Нисэх буудлын хамгаалалтын орлогоор 3300.0 мянган орлого, тендерийн баримт бичгийн үнэнд 247.5 мянга, нийт 40775.9 мянган төгрөгийг бүрдүүлжээ.

Үүнээс ОБЕГ-аас сантехникийн засварт олгосон 25000.0 мянган төгрөгийг тендер зарлаж, "RMB" ХХК-аар гүйцэтгүүлж, гамшгийн голомтод ажилласан албан хаагчдын томилолт, шатахууны зардалд 9899.6 мянга, сургалтын зардалд 2328.8 мянга, бичиг хэргийн зардалд 247.5 мянга, урсгал засварын зардалд 3300.0 мянга, нийт 40775.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 33 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 90949.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 60000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 749.5 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 30200.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 749.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Байгууллагын даргын тушаалаар 5 албан хаагчид 749.5 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн

албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэсэнтэй нийцэхгүй, "Үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий албан хаагчдаар илүү олгосон үр дүнгийн урамшууллын 749.5 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн 30200.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газарт Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2017, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, аудит хийгээгүй болно. 2019 оны эхний 30000.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тодруулах явцад 2016 онд "Сод ноёд" ХХК-д шилжүүлсэн 30000.0 мянган төгрөгийн авлага байна.

Энэ талаар байгууллагын даргаар ажиллаж байсан Т.Мөнхбаатараас тодруулахад тус мөнгөөр автомашин худалдаж аваагүй, харин автомашины гаражийн өргөтгөлийг барьсан. Мөн Аврагч спорт заал барьсан боловч одоог хүртэл мөнгийг гаргаж аваагүй гэсэн тайлбарыг өгсөн.

Үүнийг аудитын явцад аймгийн ОБГ-аас тодруулж шалгахад:

- "2017 онд үндсэн хөрөнгийн бүртгэлд спорт заалыг 160000.0 мянга, гаражийг 30000.0 мянган төгрөгөөр бүртгэж, үнэ төлбөргүй орлого, бусад эх үүсвэрээс бүртгэсэн. Тус барилга байгууламжуудыг хүлээн авсан акт, нотломжийг байгууллагын архивт хүлээлгэн өгсөн баримтыг санхүүгийн баримтаас хайлгахад ямар нэгэн хүлээн авсан акт, нотломж олдоогүй болно" гэсэн тайлбар бүхий 18.01.25 тоот албан бичгийг 2020.02.01-ний өдөр.
- Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын даргын 2020.02.04-ний өдрийн 18.01.26 тоот албан бичигт "... авлага болон бусад асуудлыг ОБЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газраас 2019 оны эхний улиралд шалгасан, тус газрын дээрх авлага, хөрөнгө болон бусад асуудлаар аймгийн Прокурорын газраас 2019 оны 07 дугаар сард мэдэгдэл ирсэн бөгөөд одоо Авлигатай тэмцэх газарт мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа болно. Тус газрын 2017 оны үйл ажиллагааны тайланд Аврагч спорт заалыг өөрсдийн хүч, нөөц бололцоог ашиглан 160.0 гаруй сая төгрөгийн өртгөөр барьж байгуулан ашиглалтад өгсөн талаар дурьдсаныг хавсралтаар хүргүүлэв" гэсэн тайлбарыг тус тус ирүүлсэн.

Мөн байгууллагын дансанд бүртгэлтэй байгаа хөрөнгөөс тооллогоор дараах хөрөнгө байхгүй байгаа талаар тайлбар өгсөн. Энэ нь аймгийн Цагдаагийн газарт хэрэг үүсгэн шалгагдаж байгаа 2018 онд хулгайд алдагдсан байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй Эрдэнэмандал хайрханы орой дээр байршуулсан 8045.4 мянган төгрөгийн дахин дамжуулагч, байгууллагын нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Доржтой холбоотой 18500.0 мянган төгрөгийн үнэ бүхий Фургон автомашины асуудал байна.

Иймд спорт заалыг ямар хөрөнгийн эх үүсвэрээр, ямар өртгөөр барьсан нь тодорхой бус, хөрөнгийг хүлээн авсан акт байхгүй, ямар анхан шатны баримтыг үндэслэн хөрөнгөд бүртгэсэн болон дээрх асуудлыг аймгийн Цагдаагийн газар, Авлигатай тэмцэх газар шалгаж хэрхэн шийдвэрлэснийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудаст оруулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	11	11	9		2	
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	95	1		
	Нийт	27	151	148	1	2	

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2017, 2018 онуудад аймгийн Онцгой байдлын газарт итгэл үзүүлсэн тул аудит хийгдээгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Насжилт өндөртэй өмнөх оны авлага 30000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 2019 оны эцэст харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт байхгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Суудлын автомашин худалдан авахтай холбоотой 2016 онд үүссэн 30000.0 мянган төгрөгийн авлагыг 2020.06.20-ны өдрийн дотор бүрэн барагдуулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг зөвшөөрч байна.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous, Payroll програмууд хэвийн ажиллаж байна. Харин 2010 онд худалдан авсан 200.0 мянган төгрөгийн архивын программыг Төрийн архивд байгууллагын цахим архивыг шилжүүлэхэд ашиглаж байгаад одоо ашиглахаа больсон байна.

2.2. Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй, ашиглалтгүй байгаа 200.0 мянган төгрөгийн үнэ бүхий архивын программыг цаашид ашиглах боломжтой эсэхийг Төрийн архивын газраас тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	466,982,659.41	571,207,630.44
33	АВЛАГА	30,000,000.00	30,000,000.00
335	Бусад авлага	30,000,000.00	30,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	30,000,000.00	30,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	436,982,659.41	541,207,630.44
351	Түүхий эд материал	3,810,832.86	3,575,054.77
35110	Тусгай зориулалттай материал	3,380,725.36	2,871,902.27
35130	Эм боох материал	430,107.50	703,152.50
354	Хангамжийн материал	433,171,826.55	471,489,869.67
35410	Бичиг хэргийн материал	1,136,200.00	1,920,600.00
35420	Аж ахуйн материал	33,243,293.88	34,155,290.88
35430	Сэлбэг хэрэгсэл	10,632,945.00	10,014,025.00
35440	Түлш, шатах тослох материал	3,637,620.00	8,542,157.00
35450	Барилгын засварын материал	3,143,000.00	525,000.00
35460	Хүнсний материал	58,000.00	258,190.00
35470	Бусад хангамжийн материал	381,320,767.67	416,074,606.79
35500	Биологийн хөрөнгө		65,042,706.00
35600	Мал амьтад	00.00	1,100,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,977,343,769.38	2,358,967,152.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,977,343,769.38	2,358,967,152.36
392	Биет хөрөнгө	1,459,088,969.38	1,840,712,352.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,019,984,420.63	1,009,130,233.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,775,586.19	-125,232,404.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,038,295,318.00	1,739,842,554.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-654,524,787.12	-861,073,084.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	267,579,421.53	265,235,152.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-206,891,898.03	-203,010,949.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,253,158.75	26,178,620.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,831,078.19	-10,357,770.30
393	Биет бус хөрөнгө	518,254,800.00	518,254,800.00
39301	Програм хангамж	1,725,000.00	1,725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,725,000.00	-1,725,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	518,254,800.00	518,254,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,444,326,428.79	2,930,174,782.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	176,662.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	176,662.00	00.00
413	Өглөг	176,662.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	176,662.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,444,149,766.79	2,930,174,782.80
51	Засгийн газрын хувь оролцоо	2,444,149,766.79	2,930,174,782.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,156,582,358.27	1,156,582,358.27
51101	Өмч: - төрийн	1,156,582,358.27	1,156,582,358.27
512	Хуримтлагдсан үр дүн	912,209,075.88	1,406,484,529.16
51210	Өмнөх үеийн үр дүн	912,209,075.88	920,459,513.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	486,025,016.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	375,358,332.64	367,107,895.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,444,326,428.79	2,930,174,782.80



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	954,533,330.15	2,454,045,816.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,647,384.15	849,583,151.46
120	Нийтлэг татварын бус орлого	65,647,384.15	849,583,151.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,647,384.15	849,583,151.46
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	65,647,384.15	849,583,151.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	888,885,946.00	1,604,462,665.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	871,173,400.00	1,563,686,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	871,173,400.00	1,563,686,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,712,546.00	40,775,965.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	2,328,800.00
131103	ЗГНХ,ЗДНХ,өрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,582,046.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	00.00	34,899,665.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,130,500.00	3,547,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,230,879,807.29	1,962,057,877.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,230,879,807.29	1,962,057,877.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,224,612,918.29	1,801,423,321.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	664,491,357.00	1,072,379,847.00
210101	Үндсэн цалин	469,310,181.00	762,491,702.00
210102	Нэмэгдэл	171,486,900.00	293,098,645.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	16,789,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,694,276.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,085,024.00	38,729,102.59
210201	Тэтгэврийн даатгал	8,022,210.00	14,257,848.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,002,778.00	1,677,396.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	802,224.00	1,341,914.00
210204	Ажлагчидгийн даатгал	198,019.00	302,440.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,059,793.00	21,149,504.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,140,090.00	125,711,708.00
210301	Гэрэл, цахилгаан	5,808,231.00	7,363,908.00
210302	Тулц, халаалт	80,441,400.00	115,457,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,890,459.00	2,890,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,812,195.67	86,153,047.32
210401	Бичиг хэрг	3,903,550.00	2,930,900.00
210402	Тээвэр, шатахуун	41,611,580.00	75,888,291.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,862,767.00	3,554,999.23
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,581,409.00
210408	Бараа материал акалсны зардал	15,434,298.67	1,197,448.09
2105	Нормативт зардал	98,186,761.05	68,330,930.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	319,798.50	451,455.00
210502	Хоол, хүнс	12,119,815.00	37,704,810.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	85,747,147.55	30,174,665.04
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,181,830.50	19,885,445.00
210604	Урсгал засвар	20,181,830.50	19,885,445.00
2107	Томилолт, зочны зардал	1,636,800.00	1,636,800.00
210702	Дотоод албан томилолт	1,636,800.00	1,636,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,428,233.00	40,615,225.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,403,146.00	35,154,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,072,449.00	1,130,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	977,800.00	1,261,193.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	385,000.00	418,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	817,000.00	434,500.00
210807	Газрын төлбөр	772,838.00	1,976,832.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	239,650,627.07	347,981,216.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,996,300.00	5,617,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,759,200.00	2,024,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	213,895,127.07	340,339,216.59
13	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,266,889.00	160,634,556.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	848,800.00	3,550,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	848,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,418,089.00	157,084,556.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,418,089.00	157,084,556.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-276,346,477.14	491,987,938.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	54,647,941.00	5,962,922.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	5,962,922.73
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	54,647,941.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-54,647,941.00	-5,962,922.73
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-330,994,418.14	486,025,016.01

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	890,658,474.00	1,604,462,665.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,772,528.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,772,528.00	00.00
120009	Бусад орлого	1,772,528.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	888,885,946.00	1,604,462,665.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	871,173,400.00	1,563,686,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	871,173,400.00	1,563,686,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,712,546.00	40,775,965.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	2,328,800.00
131103	ЗГНХ,ЗДНХ,хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,582,046.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	34,899,665.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,130,500.00	3,547,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	915,375,246.00	1,582,532,665.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	915,375,246.00	1,582,532,665.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	909,108,357.00	1,421,898,108.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,087,223.00	1,072,556,509.00
210101	Үндсэн цалин	469,868,523.00	762,668,364.00
210102	Нэмэгдэл	171,486,900.00	293,098,645.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	16,789,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,731,800.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,085,024.00	38,729,102.59
210201	Тэтгэврийн даатгал	7,943,151.00	14,257,848.00
210202	Тэтгэмжийн даатгал	992,894.00	1,677,396.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	794,317.00	1,341,914.00
210204	Ажил үйлдлийн даатгал	196,043.00	302,440.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,158,619.00	21,149,504.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,376,990.00	128,666,708.00
210301	Гэрэл, цахилгаан	5,808,231.00	7,363,908.00
210302	Түлш, халаалт	80,678,300.00	118,412,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,890,459.00	2,890,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,557,867.00	82,203,899.23
210401	Бичиг хэрэг	1,588,400.00	3,074,150.00
210402	Тээвэр, шагахуун	42,106,700.00	74,074,750.00
210403	Шуудан, холбоо, инернэтийн төлбөр	2,862,767.00	3,554,999.23
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	11,509,020.00	38,722,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	376,020.00	724,500.00
210502	Хоол, хүнс	11,133,000.00	37,815,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	183,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,229,300.00	4,645,400.00
210601	Багаж, техник хэрэгсэл	1,120,000.00	2,535,000.00
210604	Урсгал засвар	14,109,300.00	2,110,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,636,800.00	1,636,800.00
210702	Дотоод албан томилолт	1,636,800.00	1,636,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,277,633.00	46,604,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,712,546.00	40,775,965.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,072,449.00	1,130,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	977,800.00	1,261,193.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	385,000.00	418,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,357,000.00	802,500.00
210807	Газрын төлбөр	772,838.00	1,976,832.00



**Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,348,500.00	8,132,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,834,300.00	5,617,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,514,200.00	2,514,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,266,889.00	160,634,556.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	848,800.00	3,550,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	848,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,418,089.00	157,084,556.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,418,089.00	157,084,556.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-24,716,772.00	21,930,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	500,000.00	21,930,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,000.00	21,930,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	500,000.00	21,930,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	500,000.00	21,930,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-500,000.00	-21,930,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-25,216,772.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,216,772.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,042,860.19	216,528,453.86	863,022,001.47	1,479,593,315.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,739,176.06	5,739,176.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	400,042,860.19	216,528,453.86	868,761,177.53	1,485,332,491.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-5,739,176.06	00.00	-5,739,176.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	53,373,696.66	53,373,696.66
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	375,358,332.64	912,209,075.88	2,444,149,766.79
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	375,358,332.64	912,209,075.88	2,444,149,766.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,250,437.27	8,250,437.27
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,156,582,358.27	375,358,332.64	920,459,513.15	2,452,400,204.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-8,250,437.27	00.00	-8,250,437.27
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Галаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	486,025,016.01	486,025,016.01
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	367,107,895.37	1,406,484,529.16	2,930,174,782.80



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт/хэмнэлт	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,563,686,700.00	1,406,602,143.82	-157,084,556.18	90.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,563,686,700.00	1,406,602,143.82	-157,084,556.18	90.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,560,136,700.00	1,403,052,143.82	-157,084,556.18	89.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,211,558,800.00	1,072,556,509.00	-139,002,291.00	88.5
Үндсэн цалин	850,946,300.00	762,668,364.00	-88,277,936.00	89.6
Нэмэгдэл	346,583,700.00	293,098,645.00	-53,485,055.00	84.6
Унаа хоолны хөнгөлөлт	14,028,800.00	16,789,500.00	2,760,700.00	119.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,729,200.00	38,729,102.59	-97.41	100.0
Тэтгэврийн даатгал	11,736,400.00	14,257,848.00	2,521,448.00	121.5
Тэтгэмжийн даатгал	1,380,800.00	1,677,396.00	296,596.00	121.5
ҮОМШӨ-ний даатгал	1,104,600.00	1,341,914.00	237,314.00	121.5
Ажилгүйдлийн даатгал	276,200.00	302,440.00	26,240.00	109.5
Эрүүл мэндийн даатгал	24,231,200.00	21,149,504.59	-3,081,695.41	87.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,909,400.00	128,666,708.00	-14,242,692.00	90.0
Гэрэл, цахилгаан	12,973,400.00	7,363,908.00	-5,609,492.00	56.8
Түлш, халаалт	126,275,200.00	118,412,000.00	-7,863,200.00	93.8
Цэвэр, бохир ус	3,660,800.00	2,890,800.00	-770,000.00	79.0
Хангамж, бараа материалын зардал	82,203,900.00	82,203,899.23	-0.77	100.0
Бичиг хэрэг	2,737,600.00	3,074,150.00	336,550.00	112.3
Тээвэр, шагахуун	74,411,300.00	74,074,750.00	-336,550.00	99.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,555,000.00	3,554,999.23	-0.77	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
Нормативт зардал	38,722,800.00	38,722,800.00	0.00	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	724,500.00	724,500.00	0.00	100.0
Хоол, хүнс	37,815,000.00	37,815,000.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	183,300.00	183,300.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	26,575,400.00	26,575,400.00	0.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	24,465,000.00	24,465,000.00	0.00	100.0
Урсгал засвар	2,110,400.00	2,110,400.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	1,636,800.00	1,636,800.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	1,636,800.00	1,636,800.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,668,400.00	5,828,925.00	-3,839,475.00	60.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	1,130,400.00	1,130,400.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	4,817,800.00	1,261,193.00	-3,556,607.00	26.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	643,100.00	418,000.00	-225,100.00	65.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	802,500.00	802,500.00	0.00	100.0
Газрын төлбөр	2,034,600.00	1,976,832.00	-57,768.00	97.2
Бараа үйлчилгээний бусад зардал	81,320,000.00	81,320,000.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,617,800.00	5,617,800.00	0.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,514,200.00	2,514,200.00	0.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,550,000.00	3,550,000.00	0.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	3,550,000.00	3,550,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,550,000.00	3,550,000.00	0.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,563,686,700.00	1,406,602,143.82	-157,084,556.18	90.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,563,686,700.00	1,406,602,143.82	-157,084,556.18	90.0
Улсын төсвөөс санхүүжих	1,563,686,700.00	1,406,602,143.82	-157,084,556.18	90.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	113.00	106.00	-7.00	93.8
Удирдах ажигтан	01.00	01.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	112.00	105.00	-7.00	93.8
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	113.00	106.00	-7.00	93.8
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	92.00	86.00	-6.00	93.5
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21.00	20.00	-1.00	95.2

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		40,775,965.00
УРСГАЛ ЗАРДАЛ		40,775,965.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		40,775,965.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		40,775,965.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		40,775,965.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	40,775,965.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		40,775,965.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,328,800.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		34,899,665.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт		3,547,500.00

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

Огноо: 2020.02.04

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.02.04

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.04